



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/80/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас:70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: З.Ганбаатар
Утас: 70342716 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.09.24 № 152

танай _____ ны № _____ т

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Н.ГАНХӨЛӨГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хишиг-Өндөр сумын ЗДТГ нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 7 зорилтын хүрээнд 88 ажил төлөвлөснөөс 66 ажлыг биелүүлж биелэлт 83.4 хувийн биелэлттэйгээр тайлагнасан байна.

Тайлант онд оны эхний үлдэгдлээс 15,800.0, орон нутгийн төсвөөс 456,362.4, нэмэлт санхүүжилт 19,560.4, бусад орлого 4,857.0 нийт 496,579.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 465,414.4 мянган төгрөгийг зарцуулж 15,392.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 7 зорилтын хүрээнд 88 ажил төлөвлөснөөс 66 ажлыг биелүүлж биелэлт 83.4 хувийн биелэлттэйгээр тайлагнасан байна.

006020189

Тайлант онд улсын төсвөөс 284,754.0, орон нутгийн төсвөөс 49,850.1, үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө 4,469.5, бусад орлого 103.5 нийт 339,177.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 348,871.3 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>192,330,007.48</u>	<u>228,720,738.48</u>
33	АВЛАГА	25,884,676.00	22,882,825.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	15,737,726.00	13,995,875.00
335	Бусад авлага	10,146,950.00	8,886,950.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10,146,950.00	8,886,950.00
35	БАРАА МАТЕРИАЛ	155,945,331.48	195,337,913.48
351	Түүхий эд материал	88,411,284.29	131,045,284.29
35110	Тусгай зориулалттай материал	88,411,284.29	131,045,284.29
354	Хангамжийн материал	67,534,047.19	64,292,629.19
35410	Бичиг хэргийн материал	197,300.00	197,300.00
35420	Аж ахуйн материал	62,525,428.00	60,444,010.00
35470	Бусад хангамжийн материал	3,651,319.19	3,651,319.19
36	НӨӨЦИЙН БАРАА	10,500,000.00	10,500,000.00
36300	Тэжээлийн нөөц	10,500,000.00	10,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>704,243,672.26</u>	<u>759,860,785.74</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	704,243,672.26	759,860,785.74
392	Биет хөрөнгө	654,481,672.34	710,223,785.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	801,438,063.33	769,480,820.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	-486,563,306.19	-454,055,036.53
39203	Авто-тээврийн хэрэгсэл	187,434,800.00	70,494,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-181,341,973.14	-66,172,589.82
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	103,648,596.00	100,752,850.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-64,119,002.35	-47,946,608.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,274,871.67	27,274,871.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,490,069.61	-16,694,373.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	755,539,542.00	796,970,679.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-475,593,349.37	-480,114,526.56
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	9,979,400.00
39217	Ном	253,500.00	253,500.00
393	Биет бус хөрөнгө	49,761,999.92	49,636,999.88
39301	Програм хангамж	1,335,500.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,085,500.08	-375,000.12
39303	Бусад биет бус хөрөнгө	49,512,000.00	49,512,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>896,573,679.74</u>	<u>988,581,524.22</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>892,013,079.74</u>	<u>988,581,524.22</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	892,013,079.74	988,581,524.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	502,166,288.17	502,166,288.17
51101	Өмч: - төрийн	502,166,288.17	502,166,288.17
512	Хуримтлагдсан үр дүн	-6,180,944.42	90,387,500.06
51210	Өмнөх үеийн үр дүн	-6,180,944.42	-6,180,944.42
51220	Тайлант үеийн үр дүн	-	96,568,444.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	396,027,735.99	396,027,735.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>896,573,679.74</u>	<u>988,581,524.22</u>

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	495,025,520.00	668,346,598.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,737,500.00	189,221,503.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,737,500.00	189,221,503.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,737,500.00	189,221,503.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,287,500.00	4,857,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,450,000.00	184,364,503.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	474,288,020.00	479,125,095.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	68,246,420.00	6,962,695.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	13,300,000.00	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,656,420.00	4,865,260.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	290,000.00	1,897,435.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	406,041,600.00	472,162,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	356,741,600.00	456,362,400.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих /орон нутгийн төсөв/	49,300,000.00	15,800,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	535,333,014.47	536,286,173.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	535,333,014.47	536,286,173.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	523,466,724.47	477,913,982.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	226,258,664.00	237,552,359.00
210101	Үндсэн цалин	158,747,201.00	200,036,579.00
210102	Нэмэгдэл	54,464,170.00	37,515,780.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,128,628.00	29,586,710.00
210201	Тэтгэврийн даатгал	20,390,332.00	20,829,349.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,253,048.00	2,335,617.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,722,519.00	1,878,285.00
210204	Ажилгүйдлийн даатгал	441,826.00	442,389.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,320,903.00	4,101,070.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,003,126.00	43,045,345.00
210301	Гэрэл, цахилгаан	7,289,501.00	7,084,145.00
210302	Түлш, халаалт	33,713,625.00	35,961,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,077,250.00	16,664,826.00
210401	Бичиг хэрэг	2,139,100.00	1,607,700.00
210402	Тээвэр, шатахуун	9,231,320.00	8,861,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,706,830.00	1,781,926.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	3,974,220.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	439,600.00
2105	Нормативт зардал	-	287,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	287,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,400,940.00	6,162,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	440,000.00	58,000.00
210604	Урсгал засвар	29,960,940.00	6,104,150.00
2107	Томилот, зочны зардал	3,911,200.00	5,742,700.00

210702	Дотоод албан томилолт	3,911,200.00	5,742,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,870,068.00	853,435.00
210803	Даатгалын үйлчилгээ	329,000.00	333,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	347,535.00	348,035.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	120,000.00
210807	Газрын төлбөр	50,254.00	52,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	173,816,848.47	138,019,457.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	117,315,683.00	57,942,728.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,739,500.00	999,920.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,761,665.47	79,076,809.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,866,290.00	58,372,191.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	52,575,322.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	22,581,072.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	28,495,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,499,050.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,866,290.00	5,796,869.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,866,290.00	5,796,869.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-40,307,494.47	132,060,424.02
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	35,491,979.54
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	35,491,979.54
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-35,491,979.54
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-40,307,494.47	96,568,444.48

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	492,032,695.00	496,579,821.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,287,500.00	4,857,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,287,500.00	4,857,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,287,500.00	4,857,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,287,500.00	4,857,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	486,745,195.00	491,722,821.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,703,595.00	19,560,421.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	13,300,000.00	200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,113,595.00	16,202,986.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	290,000.00	3,157,435.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	406,041,600.00	472,162,400.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	356,741,600.00	456,362,400.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	49,300,000.00	15,800,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>462,740,495.00</u>	<u>465,414,421.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	462,740,495.00	465,414,421.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	444,097,079.00	397,446,155.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	226,258,664.00	237,552,369.00
210101	Үндсэн цалин	158,747,201.00	200,036,589.00
210102	Нэмэгдэл	54,464,170.00	37,515,780.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,128,628.00	29,586,700.00
210201	Тэтгэврийн даатгал	20,390,332.00	20,829,349.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,253,048.00	2,335,617.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,722,519.00	1,878,285.00
210204	Ажилгүйдлийн даатгал	441,826.00	442,379.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,320,903.00	4,101,070.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,003,126.00	42,644,249.00
210301	Гэрэл, цахилгаан	7,289,501.00	6,683,049.00
210302	Түлш, халаалт	33,713,625.00	35,961,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,763,230.00	16,760,456.00
210401	Бичиг хэрэг	1,825,950.00	1,642,850.00
210402	Тээвэр, шатахуун	9,230,450.00	8,861,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,706,830.00	1,781,926.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	3,974,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	499,600.00
2105	Нормативт зардал	554,900.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	554,900.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,693,660.00	9,612,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	440,000.00	3,412,900.00
210604	Урсгал засвар	14,895,660.00	6,199,250.00
2107	Томилолт, зочны зардал	3,911,200.00	5,742,700.00
210702	Дотоод албан томилолт	3,911,200.00	5,742,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,270,068.00	853,435.00
210803	Даатгалын үйлчилгээ	329,000.00	333,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	347,535.00	348,035.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	120,000.00
210807	Газрын төлбөр	50,254.00	52,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,513,603.00	53,894,096.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	104,719,303.00	52,894,166.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,794,300.00	999,930.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,643,416.00	67,968,266.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	52,575,522.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	22,581,072.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	28,495,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,499,250.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,643,416.00	15,392,744.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,643,416.00	15,392,744.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>29,292,200.00</u>	<u>31,165,400.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,292,200.00	31,165,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	24,292,200.00	31,165,400.00
222001	Тоног төхөөрөмж	19,852,200.00	31,165,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-24,292,200.00</u>	<u>-31,165,400.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,000,000.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	502,166,288.17	396,027,735.99	(6,180,944.42)	-	892,013,079.74
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл					
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	502,166,288.17	396,027,735.99	(6,180,944.42)	-	892,013,079.74
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	96,568,444.48		96,568,444.48
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	502,166,288.17	396,027,735.99	90,387,500.06	-	988,581,524.22

Төсвийн гүйцэтгэл

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	516,951,400.00	471,222,531.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	516,951,400.00	440,057,131.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	464,375,100.00	387,481,609.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,934,100.00	237,552,369.00
210101	Үндсэн цалин	204,513,900.00	200,036,589.00
210102	Нэмэгдэл	54,420,200.00	37,515,780.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,370,300.00	29,586,700.00
210201	Тэтгэврийн даатгал	22,011,500.00	20,829,349.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,590,000.00	2,335,617.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,071,700.00	1,878,285.00
210204	Ажилгүйдлийн даатгал	517,900.00	442,379.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,179,200.00	4,101,070.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,876,400.00	42,644,249.00
210301	Гэрэл, цахилгаан	6,914,800.00	6,683,049.00
210302	Түлш, халаалт	35,961,600.00	35,961,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,820,800.00	16,760,456.00
210401	Бичиг хэрэг	1,646,800.00	1,642,850.00
210402	Тээвэр, шатахуун	8,874,000.00	8,861,380.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,781,926.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,000,000.00	3,974,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	499,600.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,200,000.00	9,612,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,000,000.00	3,412,900.00
210604	Урсгал засвар	6,200,000.00	6,199,250.00
2107	Томилолт, зочны зардал	5,770,000.00	5,742,700.00

210702	Дотоод албан томилолт	5,770,000.00	5,742,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	853,500.00	853,435.00
210803	Даатгалын үйлчилгээ	333,200.00	333,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	348,100.00	348,035.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	120,000.00
210807	Газрын төлбөр	52,200.00	52,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,750,000.00	43,929,550.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,750,000.00	42,929,620.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	999,930.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,576,300.00	52,575,522.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,576,300.00	52,575,522.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,581,100.00	22,581,072.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,495,200.00	28,495,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,499,250.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	31,165,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	31,165,400.00
222001	Тоног төхөөрөмж	-	31,165,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	516,951,400.00	461,219,400.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	511,951,400.00	456,362,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	511,951,400.00	456,362,400.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	4,857,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	4,857,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тухайн жил 7 зорилтын хүрээнд 88 ажил төлөвлөснөөс 66 ажлыг биелүүлж биелэлт 83.4 хувиар дүгнүүлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, НБББББ-ийг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/179 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй /үр нөлөөгүй байна.

Дотоод хяналттай холбоотойгоор байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанартай үр дүнтэй хийсэн эсэхийг шалгах аар горим хэрэгжүүлсэн

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 92 сая төгрөгөөр буюу 10,2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	25,884.6	22,882.8	-3001,8
Бараа материал	166,445.3	205,837.9	39,392.6
Үндсэн хөрөнгө	1,926,436.8	1,825,218.9	-101217,9
Нийт хөрөнгө	896,573.6	988,581.5	92,007.9
Өр төлбөр	4,560.6	0	-4,560.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	502,166.3	502,166.3	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	896,573.6	988,581.5	92,007.9

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 39392,6 мянган төгрөгөөр өсч, үндсэн хөрөнгө 101217,9 мянган төгрөгөөр буурчээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 511.9 сая төгрөгөөр нийт зарлагыг 516,9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналын дүнгээр төсөв баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 516.9 сая төгрөгийг улсын төсвөөс, авсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 472,1 сая төгрөг, өөрийн орлогоор 4.8 сая төгрөгний орлого төвлөрүүлж, 472.0 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэлгүй гарсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	351859.6	310789.5	41070.1	88.3
2	Багийн засаг даргын төсөв	59117.8	54489.4	4628.4	92.2
3	Нийтлэг үйлчилгээ	14397.7	14397.7	0	100
4	Нэг удаагийн тэтгэмж	29995.2	29994.4	0.8	99.9
5	Засаг даргын нөөц	30000.0	29999.8	0.2	100
6	Хог хаягдал зайлуулах	4000.0	3974.7	25.3	99.4
7	Баяр наадмын зардал	5000.0	4995.6	4.4	99.9
8	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн тэтгэмж	22581.1	22581.1	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 19,560.4 мянган төгрөгний санхүүжилт орж ирсэн байна. Үүнд : Булган аймгийн Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардал 2,974.8 мянган төгрөг, шүлхий өвчний үеийн иргэдийн хандив 200.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс Цэвэр орчин цэмцгэр Булган хог цэвэрлэгээний зардал 1,500.0 мянган төгрөг, төрөөс хариуцах цэвэр усны төлбөр 4560.6 мянган төгрөг, иргэдээс ногоон тэжээлийн үнэ 1,260.0 мянган төгрөг, цахим худгийн карт цэнэглэлт 1,897.4 мянган төгрөг, 2021 оны татан төвлөрүүлэлт буцаан олголт 6,777.1 мянган төгрөг, бусад орлого 390.5 мянган төгрөг. Нэмэлт төсвийн зарцуулалт : хагас жилийн мал

тооллого 2,802.8 мянган төгрөг, цэвэр орчин цэмцгэр булган хог цэвэрлэгээ 1,257.0 мянган төгрөг, цэвэр усны төлбөр 4,560.6 мянган төгрөг, бусад зардал 1,344.2 мянган төгрөг, нийт 9,964.6 мянган төгрөг гаргав.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 496.6 сая төгрөгөөс 75 хувиар буюу 7.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн шатанд дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь өөрийн байгууллагын тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй УАЗ пургон БУЛ 18-80, Ланд криузер 69-97 БУЛ, кама 29-63 БУЛ улсын дугаартай автомашиныг төрийн хэмнэлтийн хуулийн дагуу Аймгийн ИТХ-ын 2022 оны XII дугаар хуралдааны XII/15 тогтоолоор дуудлага худалдаагаар худалдан борлуулах шийдвэр гаргуулсан байна. Шийдвэрийн дагуу 2023 онд дуудлага худалдаа зохион байгуулагдана.

Аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд нийт 148 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд 131 мэдээг бүрэн мэдээлж, хугацаа хоцорсон мэдээ 17 байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.” гэсэн заалтын дагуу хийсэн ч санхүүгийн тодруулга тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 0 төгрөгийн үлдэгдэлтэй 4298.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх эсвэл актлах зохион байгуулалттай ажиллаагүй нь дотоод хяналттай холбоотой зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Сангийн сайдын 2021 оны 347 дүгээр тушаалын хавсралтаар баталсан байгууллагын авто тээврийн хэрэгсэлд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ гэсэн зааврыг мөрдөөгүй зөрчил гаргасан.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хишиг-Өндөр сумын ЗДТГ-ын 2022 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн 1/100 тоот албан бичгээр акт, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3,385.7	1		
Албан шаардлага	3	0	3	0	100

Зөвлөмж	0	0	0	0
Нийт дүн	4	3,385.7	3	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материалын хагас жил болон жилийн эцсийн тооллогод тооцоо бодсон акт үйлдсэн эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 6.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.8 сая төгрөгийн төлбөрийн акт, дахин давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд анхан шатны баримтгүй 613,250.0 төгрөгийн шатахууныг зарцуулсан,
2. 2022 онд тамгын даргын А/38 тоот тушаалаар 18 албан хаагчдад 450,000.0 төгрөгийн нэгж олгосон,
3. Тайлант онд анхан шатны баримтгүй зарцуулсан 752,000.0 төгрөгийн албан томилолт олгосон.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 төгрөгийн дансны үнэтэй 4,298,722.77 төгрөгийн хөрөнгийн тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС-17, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т "Биет хөрөнгийн дансны үнэ бодит үнээс материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын хөрөнгө материалын тооллогын хяналтыг сайжруулж ажиллах.

2. Үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын Нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материалын хагас жил болон жилийн эцсийн тооллогод тооцоо бодсон акт үйлдээгүй.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материалын хагас жил болон жилийн эцсийн тооллогод тооцоо бодсон акт үйлдэх.

3. Төрийн хэмнэлтийн тухай хууль

Илрүүлэлт: Байгууллагын авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хууль холбогдох заалтыг баримтлан ажиллах.

4. Төрийн хэмнэлтийн тухай хууль

Илрүүлэлт: Тайлант онд шилэн дансны цахим системд нийт 148 мэдээ мэдээлэхээс 17 мэдээг хоцроож мэдээлсэн.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын шилэн дансны мэдээллийг цаг тухай бүр мэдээлэх.

Байгууллагын хөрөнгийн тооллогыг хийхдээ чанартай хийж дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	7	6.1	3	1.8	0	0	4	4.3	0	0	0	0
Дүн	7	6.1	3	1.8	0	0	4	4.3	0	0	0	0